



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 12 сарын 11 өдөр

Дугаар A/563

Улаанбаатар хот


Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн тогтвортой байдлыг зохицуулах журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн орлогын бүртгэл", "Иргэдэд олгосон жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл" болон "Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн тайлан"-гийн маягтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн тогтвортой байдлыг зохицуулах журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Т.Энхзаяа/, Эмнэлгийн тусlamжийн газар /Я.Буянжаргал/, Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Н.Гэрэлт-Од/, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 63 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Нөхөн үржихүйн эрүүл тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Засгийн газрын санхүүжилтээр нийлүүлэгдэж байгаа нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийг нийгмийн эмзэг давхаргын иргэдэд үнэ төлбөргүй олгох журмыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12
сарын 11...ны өдрийн 11/563 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХАНГАМЖИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэгцээг нэгтгэх, худалдан авалтад тавигдах шаардлага, иргэдэд олгох, зарцуулалтад хяналт тавих, тайлагнах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн тогтвортой байдлыг зохицуулах журам нь Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан Эх, хүүхэд, нөхөн үржихүйн үндэсний хөтөлбөр болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

Хоёр. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэгцээг нэгтгэх

2.1 Өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төв үйлчлэх хүрээний хүн амд шаардлагатай жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэгцээг нэгтгэн, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.

2.2 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийгмийн эрүүл мэндийн төвийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн орон нутгийн хэмжээнд шаардлагатай жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн жилийн хэрэгцээг нэгтгэн гаргана.

2.3 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийгмийн эрүүл мэндийн төвөөс өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэгцээг гаргах, гэр бүл төлөвлөлтийн аргын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

2.4 Өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төв 5 ба түүнээс дээш жирэмслэхээс сэргийлэх арга (хавсарсан дааврын эм, дан прогестерон агуулсан эм, суулгац, тария, яаралтай ууж хэрэглэх эм, бэлгэвч, ерөндөг)-ын сонголттой, 3 хүртэл сарын нөөцтэй байна.

2.5 Өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төв нь тухайн эмэгтэйд жирэмслэхээс сэргийлэх аргыг хэрэглэхэд үндсэн мэргэжлийн эмчийн тусlamж шаардагдах тохиолдолд жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төвд хуваарилах асуудлыг тухайн орон нутгийн Эрүүл мэндийн газар зохицуулалтыг хийнэ.

Гурав. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтад тавигдах шаардлага

3.1 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар орон нутгийн хэмжээнд худалдан авах жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэгцээг нэгтгэн гаргаж, аймаг, нийслэлийн худалдан авах ажиллагааны газартай хамтран Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулна.

3.2 Жирэмслэхээс сэргийлэх эмийг худалдан авахад дараах чанарын шаардлага хангасан байх шаардлагыг тавьна. Үүнд:

3.2.1 Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн;

3.2.2 Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-ын урьдчилсан баталгаажуулалтад хамрагдсан байх эсвэл эм, эмнэлгийн хэрэгслийн хатуу зохицуулалттай орны эрх бүхий байгууллагын бүртгэлийн гэрчилгээтэй;

3.2.3 Монгол Улсын Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон;

3.2.4 Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/-ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн;

3.2.5 Холбогдох фармакопейн шаардлага хангасан;

3.2.6 Худалдан авах ажиллагаанд эмийг олон улсын нэршлээр бичих ба ерөнхий нэршлийн эмийн сонголтыг дэмжих.

3.3 Жирэмслэхээс сэргийлэх эмнэлгийн хэрэгслийг худалдан авахад дараах чанарын шаардлага хангасан байх шаардлагыг тавьна. Үүнд:

3.3.1 Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-ын урьдчилсан баталгаажуулалтад хамрагдсан байх эсвэл Эм, эмнэлгийн хэрэгслийн хатуу зохицуулалттай орны эрх бүхий байгууллагын бүртгэлийн гэрчилгээтэй;

3.3.2 Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/-ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн;

3.3.3 Холбогдох олон улсын стандарт /ISO/-ын шаардлага хангасан;

3.4 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн худалдан авсан жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн тоо хэмжээг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нэгтгэнэ.

Дөрөв. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авах, хадгалах, олгох

4.1 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг энэ тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан маягт /№1/-ын дагуу орлогод авч, бүртгэнэ.

4.2 Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн аваходаа Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт түгээлтэд тавих ерөнхий шаардлага (MNS 5530:2014) стандартыг мөрдөнө.

4.3 Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг орлогод авч, тухайн бүтээгдэхүүний онцлог байдалд тохирсон нөхцөлд Эмийн санд тавих нийтлэг шаардлага (MNS 5260:2015), Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт түгээлтэд тавих ерөнхий шаардлага (MNS 5530:2014) стандартын дагуу хадгална.

4.4 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг шаардлагатай хүн амд олгох ба нэн тэргүүнд зорилтот бүлгийн хүн амыг судалгааны дагуу хамруулна.

4.5 Зорилтот бүлэгт Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас орлогыг орлуулан тооцох аргаар тогтоосон ядуу, эмзэг давхаргад хамрагддаг иргэд, эрүүл мэндийн заалтаар жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг зайлшгүй хэрэглэх шаардлагатай иргэд, өсвөр, залуу үе, алслагдсан бүс нутагт оршин суугаа иргэдийг холбогдох судалгааны дагуу хамруулна.

4.6 Иргэдэд олгосон жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтыг энэхүү журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан маягт /№2/-ын дагуу бүртгэл хөтөлнө.

4.7 Эрүүл мэндийн байгууллагууд иргэдэд олгосон жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг өвчний олон улсын 10 дугаар ангилалын Z30 оношийн бүлгийн дагуу Эрүүл мэндийн яамнаас зөвшөөрөгдсөн програмд бүртгэж, мэдээний сан үүсгэнэ.

4.8 Эрүүл мэндийн байгууллагууд иргэдэд жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг олгохдоо эм, эмнэлгийн хэрэгслийн сонголт, эмийн гаж нөлөө, хэрэглэх заалтын талаар мэдээлэл өгнө.

Тав. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтад тавих хяналт

5.1 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтад хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

5.2 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар жилд нэгээс доошгүй удаа харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж болон зарцуулалтын байдалд үнэлгээ хийнэ.

5.3 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах гэрээний биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцон, биелэлт хангалтгүй тохиолдолд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт мэдэгдэнэ. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар хууль өрх зүйн хүрээнд шаардлагатай арга хэмжээг авна.

Зургаа. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн тайлагналт

6.1 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын тайлан болон нөөцийн мэдээллийг энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан маягт /№3-/ын дагуу улирлаар гаргаж, дараа улирлын эхний сарын 5-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.

6.2 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар тухайн жилд хэрэглэсэн жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын тайланг нэгтгэн дараа оны 1 дүгээр сард багтаан, нөөцийн мэдээллийг улирлаар нэгтгэн гаргаж дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эмийн асуудал хариуцсан албанд тус тус хүргүүлнэ.

6.3 Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эмийн асуудал хариуцсан алба тухайн жилд улсын хэмжээнд хэрэглэсэн жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын тайланг нэгтгэн дараа оны 2 дугаар сард багтаан, нөөцийн мэдээллийг улирлаар нэгтгэн дараа сарын 30-ны өдрийн дотор Эрүүл мэндийн яаманд тус тус хүргүүлнэ.

6.4 Эрүүл мэндийн яам жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалт, үр дүнгийн талаарх тайлан, нөөцийн мэдээлэлд үндэслэн дараа жилийн төлөвлөлт болон бодлого, шийдвэрт тусгах ажлыг хэрэгжүүлнэ.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны **жар**
ны өдрийн **дугаар** тушаалын хоёрд
хавсралт

May

ЖИРЭМСЛЭХЭС СЭРГИЙЛЭХ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ОРЛОГЫН БУРТГЭЛ

ИРГЭДЭД ОЛГОСОН ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛПЭХ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН БУРТГЭЛИЙН МАЯТ

№	Овог нэр	Нас	Боловсрол	Хаяг	Регистрийн дугар	Хэрэглэгч	Жирэмстхээс сэргийлэх эмнэлийн нэр, гарын үсэг	Олондоо ажилтнуулж, төслийн нийтийн нэр, гарын үсэг
						Хавсарсан дааврын эм		
						Дан прогестерон агуулсан эм		
						Яаралтай ууж хэрэглэх эм		
						Тария		
						Суулгац		
						Ерэндөг		
						Бэлгэвч		
						Бусад		
						Хэрэгслийг сольсон шалгаан		

May

Mar

**ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ
ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТАЙЛАНГИЙН МАЯГТ**

Өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн нэр.

.....р упирал

Тайлан гаргасан хүний овог нэр, албан тушал.